



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 13/0

Эрдэнэт

Бодлого батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1.2.а дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.1, 14.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 19 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

Нэг.Орхон аймаг, Эрдэнэт хотын “Ногоон, тогтвортой хөгжлийн хэтийн зорилт-2025” бодлогын баримт бичгийг хавсралтаар баталсугай.

Хоёр.Аймгийн Засаг дарга /Д.Батлут/-д ДААЛГАХ нь:

2.1.Орхон аймаг, Эрдэнэт хотын “Ногоон, тогтвортой хөгжлийн хэтийн зорилт-2025” бодлогыг хэрэгжүүлэх ажлыг аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан зохион байгуулах.

2.2.Орхон аймаг, Эрдэнэт хотын “Ногоон, тогтвортой хөгжлийн хэтийн зорилт-2025” бодлогын хэрэгжилтийг дүгнэж, жил бүрийн IY улиралд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах.

ДАРГА



П.ПҮРЭВЛХАГВА